

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/216/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
[www.audit.mn](#)
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Энхбаатар
Утас: 51-260512 Цахим хаяг: Enkhbaatare@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Батцэцэг
Утас: 51-261628 Цахим хаяг: Battsetsegp@audit.gov.mn
Аудитор: Ч.Мөнхбулган
Утас: 51-261628 Цахим хаяг: Munkhbulganch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЦС	Дулааны цахилгаан станц
МУЕС	Монгол Улсын Ерөнхий сайд
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СҮДТ	Санхүүгийн үр дүнгийн тайлан
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/286

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчийн байгууллагын байр талбайн түрээсийн орлогын 40 хувь буюу 101,604.5 мянган төгрөгийг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 779,970.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, 21 аймаг, нийслэлийн орон нутгийн өмчийн газар, төрийн болон орон нутгийн өмчит 7000 орчим байгууллагын өмчийн харилцааны үйл ажиллагааг нэг платформ дээр төвлөрүүлж, бүх шатны өмчийн бүртгэл, хяналт, удирдлагыг цахимжуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн систем”-ийг хүлээн авч, ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 101,600,000.0 мянган төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлийг Төв төрийн сан дахь ногдол ашгийн болон түрээсийн орлогын дансанд төвлөрүүлж байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Төсвийн тухай хууль, Монгол Улсын тухайн оны төсвийн тухай хуулиуд, Ирээдүй өв сангийн тухай хуулийг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг тогтоодог боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын “Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох” бүрэн эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамаараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten Signature] Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,028,474,384.81	266,544,751.93
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	213,007,000.00	48,558,500.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	213,007,000.00	48,558,500.00
31210	Төгрөг	213,007,000.00	48,558,500.00
31211	Төрийн сангийн харилцах	213,007,000.00	48,558,500.00
33	АВЛАГА	200,994.02	125,651,529.93
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	125,651,529.93
33500	Бусад авлага	200,994.02	-
33510	Байгууллагаас авах авлага	200,994.02	-
34	УРЬДЧИЛГАА	1,059,970,000.00	15,922,550.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,059,970,000.00	15,922,550.00
35	БАРАА МАТЕРИАЛ	77,961,522.02	76,412,172.00
35400	Хангамжийн материал	77,961,522.02	76,412,172.00
35410	Бичиг хэргийн материал	11,631,010.02	7,144,750.00
35420	Аж ахуйн материал	298,440.00	2,886,200.00
35440	Түлш, шатах тослох материал	6,760,000.00	22,750,100.00
35470	Бусад хангамжийн материал	59,272,072.00	43,631,122.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,677,334,868.77	-
36800	Бусад эргэлийн хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	1,677,334,868.77	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,764,972,186.48	3,659,532,356.19
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,764,972,186.48	3,659,532,356.19
39200	Биет хөрөнгө	2,673,993,886.44	2,828,506,056.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,750,780,584.00	2,750,780,584.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(397,644,417.66)	(463,968,732.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,600,000.00	55,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,633,333.34)	(37,033,333.38)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	456,547,226.27	682,490,972.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(245,259,248.77)	(225,064,954.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	128,719,695.00	121,764,149.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,116,619.06)	(56,062,629.35)
39300	Биет бус хөрөнгө	90,978,300.04	831,026,300.04
39301	Программ хангамж	68,615,000.00	848,585,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(39,482,499.96)	(79,404,499.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	61,845,800.00	61,845,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,793,446,571.29	3,926,077,108.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	165,554,000.00	51,280,085.47
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	165,554,000.00	51,280,085.47
41300	Өглөг	165,554,000.00	12,281,585.47
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,721,585.47
41360	Бусад өглөг	165,554,000.00	9,560,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	165,554,000.00	9,560,000.00
41400	Урьдчилж орсон орлого	-	38,998,500.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	38,998,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,627,892,571.29	3,874,797,022.65
51	Засгийн газрын хувь оролцоо	5,627,892,571.29	3,874,797,022.65
51100	Засгийн газрын оруулсан капитал	35,655,560.00	35,655,560.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	35,655,560.00	35,655,560.00
51200	Хуримтлагдсан үр дүн	5,194,170,476.34	3,441,074,927.70
51210	Өмнөх үеийн үр дүн	4,253,288,399.15	5,215,734,676.34
51220	Тайлант үеийн үр дүн	940,882,077.19	(1,774,659,748.64)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,066,534.95	398,066,534.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,793,446,571.29	3,926,077,108.12

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	48,231,468,900.68	2,810,773,860.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,309,354,800.68	2,810,773,860.60
120	Нийтлэг татварын бус орлого	44,082,859,050.68	279,462,058.60
120001	Хувьцааны ногдол ашиг	40,073,832,984.68	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,000,041.36	211,228,529.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,041.36	211,228,529.93
120005	Түрээсийн орлого	3,852,277,544.97	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	151,748,479.67	68,103,528.67
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	130,000.00
121	Хөрөнгийн орлого	226,495,750.00	-
121002	Өмч хувьчлалын орлого	226,495,750.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,922,114,100.00	2,531,311,802.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,788,043,600.00	2,531,311,802.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,728,073,600.00	2,531,311,802.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,059,970,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,070,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,070,500.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	47,204,593,229.00	4,585,433,609.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,204,593,229.00	4,585,433,609.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,821,034,034.89	4,466,200,802.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,671,258,359.33	1,843,797,946.69
210101	Үндсэн цалин	987,472,901.95	989,161,873.24
210102	Нэмэгдэл	326,160,041.78	403,988,874.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	229,372,000.00	301,231,365.81
210104	Урамшуулал	128,253,415.60	149,415,833.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,749,447.95	227,321,105.72
210201	Тэтгэврийн даатгал	139,648,285.20	155,252,938.13
210202	Тэтгэмжийн даатгал	16,706,103.57	18,458,627.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,313,451.83	9,182,153.81
210204	Ажилгүйдлийн даатгал	8,151,988.02	8,885,477.26
210205	Эрүүл мэндийн даатгал	31,929,619.33	35,541,908.89
2104	Хангамж, бараа материалын зардал	81,507,377.00	1,775,357,368.79
210401	Бичиг хэрэг	17,465,447.00	15,444,860.02
210402	Тээвэр, шатахуун	17,553,800.00	19,140,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,218,350.00	36,962,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,458,380.00	4,911,240.00
210408	Бараа материал акталсны зардал	15,811,400.00	-
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	1,698,899,068.77
2107	Томилолт, зочны зардал	318,684,335.00	91,547,194.00
210701	Гадаад албан томилолт	173,958,050.00	-
210702	Дотоод албан томилолт	144,726,285.00	91,547,194.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	278,931,651.42	264,026,127.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	265,728,428.42	246,210,011.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	395,330.00
210803	Даатгалын үйлчилгээ	610,583.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,800.00	1,118,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,200.00	20,000.00

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,526,640.00	16,282,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	265,902,864.19	264,151,058.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,425,026.00	3,948,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,768,700.00	2,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	223,709,138.19	258,202,458.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,383,559,194.11	119,232,807.19
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	32,692,759.95
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	32,692,759.95
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	32,692,759.95
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	32,692,759.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	188,391,634.00	86,540,047.24
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	68,472,800.00	44,516,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,476,514.00	42,024,047.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,442,320.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,195,167,560.11	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,502,698.66	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	44,166,664,861.45	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	85,993,594.49	(1,774,659,748.64)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	85,993,594.49	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	85,831,111.07	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	162,483.42	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	940,882,077.19	(1,774,659,748.64)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	48,287,733,002.81	2,781,538,831.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,365,618,902.81	2,781,538,831.93
120	Нийтлэг татварын бус орлого	44,139,123,152.81	250,227,029.93
120001	Хувьцааны ногдол ашиг	40,073,832,984.68	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,000,041.36	211,228,529.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,041.36	211,228,529.93
120005	Түрээсийн орлого	3,866,336,126.77	-
120009	Бусад орлого	193,954,000.00	38,998,500.00
121	Хөрөнгийн орлого	226,495,750.00	-
121002	Өмч хувьчлалын орлого	226,495,750.00	-
122	Тусламжийн орлого	-	2,531,311,802.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,531,311,802.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,531,311,802.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,531,311,802.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,922,114,100.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,788,043,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,728,073,600.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	1,059,970,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	134,070,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,070,500.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,000,984,128.81	2,786,868,431.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,000,984,128.81	2,786,868,431.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,620,584,934.70	2,541,984,094.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,696,629,662.78	1,841,076,361.22
210101	Үндсэн цалин	934,496,841.62	986,440,287.77
210102	Нэмэгдэл	335,992,583.33	403,988,874.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	297,998,096.03	301,231,365.81
210104	Урамшуулал	128,142,141.80	149,415,833.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,400,128.50	227,321,105.72
210201	Тэтгэврийн даатгал	141,038,936.92	155,252,938.13
210202	Тэтгэмжийн даатгал	16,751,535.16	18,458,627.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,355,967.62	9,182,153.81
210204	Ажилгүйдлийн даатгал	8,250,737.81	8,885,477.26
210205	Эрүүл мэндийн даатгал	33,002,950.99	35,541,908.89
2104	Хангамж, бараа материалын зардал	64,757,780.00	91,681,250.00
210401	Бичиг хэрэг	12,848,000.00	8,007,100.00
210402	Тээвэр, шатахуун	19,620,000.00	35,000,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	24,887,300.00	36,962,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,402,480.00	11,711,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	649,900.00
210602	Тавилга	-	649,900.00
2107	Томилолт, зочны зардал	318,684,335.00	91,547,194.00
210701	Гадаад албан томилолт	173,958,050.00	-
210702	Дотоод албан томилолт	144,726,285.00	91,547,194.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	282,800,302.42	279,747,683.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	269,317,079.42	246,009,017.87
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	395,330.00

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	610,583.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,800.00	1,118,536.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	39,200.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,806,640.00	32,204,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,312,726.00	9,960,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,314,026.00	7,960,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,998,700.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,380,399,194.11	244,884,337.12
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	143,921,289.88
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	143,921,289.88
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	143,921,289.88
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	32,692,759.95
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	111,228,529.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	185,231,634.00	86,540,047.24
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	65,312,800.00	44,516,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,476,514.00	42,024,047.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,442,320.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,195,167,560.11	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,502,698.66	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	44,166,664,861.45	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	14,423,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,423,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,286,748,874.00	(5,329,600.00)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,116,041,874.00	159,118,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,116,041,874.00	159,118,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,116,041,874.00	159,118,900.00
220001	Барилга байгууламж	1,059,970,000.00	155,994,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	56,071,874.00	3,124,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,116,041,874.00)	(159,118,900.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	170,707,000.00	(164,448,500.00)
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,300,000.00	213,007,000.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	213,007,000.00	48,558,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,334,978,875.85	4,768,700,970.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(81,690,476.70)	(81,690,476.70)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,253,288,399.15	4,687,010,494.10
Тайлант үеийн үр дүн	-	-	940,882,077.19	940,882,077.19
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	5,194,170,476.34	5,627,892,571.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	21,564,200.00	21,564,200.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	5,215,734,676.34	5,649,456,771.29
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,774,659,748.64)	(1,774,659,748.64)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	3,441,074,927.70	3,874,797,022.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,848,141,700.00	2,709,847,571.98	138,294,128.02	95.1
Татварын бус орлого	2,848,141,700.00	2,709,847,571.98	138,294,128.02	95.1
Нийтлэг татварын бус орлого	100,000,000.00	211,228,529.93	(111,228,529.93)	211.2
Төсөвт байгууллагын өөрийн орлого /үндсэн/	100,000,000.00	211,228,529.93	(111,228,529.93)	211.2
Тусламжийн орлого	2,748,141,700.00	2,498,619,042.05	249,522,657.95	90.9
Төсвөөс санхүүжих	2,748,141,700.00	2,498,619,042.05	249,522,657.95	90.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,848,141,700.00	2,598,619,042.05	249,522,657.95	91.2
УРСГАЛ ЗАРДАЛ	2,848,141,700.00	2,598,619,042.05	249,522,657.95	91.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,784,018,500.00	2,545,108,994.81	238,909,505.19	91.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,884,151,300.00	1,841,076,361.22	43,074,938.78	97.7
Үндсэн цалин	1,032,705,200.00	986,440,287.77	46,264,912.23	95.5
Нэмэгдэл	413,783,300.00	403,988,874.54	9,794,425.46	97.6
Унаа хоолны хөнгөлөлт	303,047,800.00	301,231,365.81	1,816,434.19	99.4
Урамшуулал	134,615,000.00	149,415,833.10	(14,800,833.10)	111.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	237,711,100.00	227,321,105.72	10,389,994.28	95.6
Тэтгэврийн даатгал	161,663,200.00	155,252,938.13	6,410,261.87	96.0
Тэтгэмжийн даатгал	19,028,300.00	18,458,627.63	569,672.37	97.0
ҮОМШӨ-ний даатгал	9,512,400.00	9,182,153.81	330,246.19	96.5
Ажилгүйдлийн даатгал	9,501,500.00	8,885,477.26	616,022.74	93.5
Эрүүл мэндийн даатгал	38,005,700.00	35,541,908.89	2,463,791.11	93.5
Хангамж, бараа материалын зардал	103,688,300.00	91,681,250.00	12,007,050.00	88.4
Бичиг хэрэг	11,696,300.00	8,007,100.00	3,689,200.00	68.5
Тээвэр, шатахуун	38,769,700.00	35,000,100.00	3,769,600.00	90.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,962,200.00	36,962,200.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,260,100.00	11,711,850.00	4,548,250.00	72.0
Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	649,900.00	5,350,100.00	10.8
Тавилга	6,000,000.00	649,900.00	5,350,100.00	10.8
Томилолт, зочны зардал	94,521,000.00	91,547,194.00	2,973,806.00	96.9
Дотоод албан томилолт	94,521,000.00	91,547,194.00	2,973,806.00	96.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	444,861,300.00	279,747,683.87	165,113,616.13	62.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	251,764,700.00	246,009,017.87	5,755,682.13	97.7
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	395,400.00	395,330.00	70.00	100.0
Даатгалын үйлчилгээ	594,100.00	-	594,100.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	1,242,300.00	1,118,536.00	123,764.00	90.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	59,200.00	20,000.00	39,200.00	33.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	190,805,600.00	32,204,800.00	158,600,800.00	16.9
Бараа үйлчилгээний бусад зардал	13,085,500.00	13,085,500.00	-	100.0

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа үйлчилгээний бусад зардал	11,085,500.00	11,085,500.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,123,200.00	53,510,047.24	10,613,152.76	83.4
Бусад урсгал шилжүүлэг	64,123,200.00	53,510,047.24	10,613,152.76	83.4
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,486,000.00	11,486,000.00	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,637,200.00	42,024,047.24	10,613,152.76	79.8
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	111,228,529.93	(111,228,529.93)	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(111,228,529.93)	111,228,529.93	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(111,228,529.93)	111,228,529.93	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	51	51	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	45	42	3	93.3
Үйлчлэх ажилтан	5	8	(3)	160.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	51	(4)	108.5
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	40	43	(3)	107.5
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	8	(1)	114.3
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1	-	100.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эрхэм зорилгоо “Төрийн өмчийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлагыг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хэрэгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Тус газар нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах, бүртгэлээр хяналт тавих, төрийн өмчит хуулийн этгээдэд компанийн сайн засаглалыг нэвтрүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, стратеги төлөвлөгөөг батлах, төрийн өмчийг хувьчлах, хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөх, татан буулгах, төрийн өмчийн улсын үзлэг, тооллого хийх, орон нутгийн өмчийн асуудлаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй боловч, төсөвт байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд төсөвт байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлого болон түрээсийн орлогыг төв төрийн санд шууд төвлөрүүлдэг болсон байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод хөрөнгийн шинж чанартай 21,564.2 мянган төгрөгийн хөрөнгүүдийг бараа материалын данснаас үндсэн хөрөнгийн дансанд залруулга бичилт хийсэн дүнгээр өөрчлөлт орсон байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,867,369.5 мянган төгрөгөөр буюу 32.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	213,007.0	48,558.5	(164,448.5)
Авлага	201.0	125,651.5	125,450.5
Урьдчилгаа	1,059,970.0	15,922.5	(1,044,047.5)
Бараа материал	77,961.5	76,412.2	(1,549.3)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,677,334.9	-	(1,677,334.9)
Үндсэн хөрөнгө	2,764,972.2	3,659,532.4	894,560.2
Нийт хөрөнгө	5,793,446.6	3,926,077.1	(1,867,369.5)
Өр төлбөр	165,554.0	51,280.1	(114,273.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,627,892.6	3,874,797.0	(1,753,095.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,793,446.6	3,926,077.1	(1,867,369.5)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах дансдууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн мэдээллийн системийн үлдэгдэл санхүүжилтийг барьцаа данснаас олгосноор 164,448.5 мянган төгрөгөөр буурсан;
- Авлага дансны үлдэгдэл ахмадын сангийн үлдэгдэл болон үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэснээр 125,450.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Урьдчилгаа дансны үлдэгдэл нь 15,922.5 мянган төгрөгт хүрсэн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийн тоног төхөөрөмж, мэдээллийн системийг хүлээн авч үндсэн хөрөнгөд бүртгэхэд урьдчилгаа дансны үлдэгдлийг 1,059,970.0 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой;
- Тайлант онд бараа материал худалдаж авсан 57,896.6 мянган төгрөг, шатахууны хөнгөлөлт 130.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 38,011.7 мянган төгрөг, хөрөнгийн шинж чанартай зүйлсийн үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 21,564.2 мянган төгрөгөөр тус тус хасагдсан;
- Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газруудад ашиглагдаж байсан хөрөнгүүдийг орон нутгийн өмчид шилжүүлсэн ТӨБЗГ-ын 2025 оны 517 дугаар тогтоолын 1,677,334.9 мянган төгрөгөөр буурсан;

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн системийн тоног төхөөрөмж, мэдээллийн системийн 1,063,094.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 258,202.5 мянган төгрөгөөр буурсан;
- Өр төлбөр данс Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийн мэдээллийн системийн үлдэгдэл санхүүжилтийг олгосноор буурсан;
- Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 1,753,095.6 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Биет бус хөрөнгийн дансанд нийт 848,585.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн систем, Нэгдсэн хөрөнгийн тооллогын программ, Санхүүгийн программ бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,409,692.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр, нийт зарлагыг 4,414,692.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний зардлыг 732,346.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 145,600.0 мянган төгрөг, нийт 877,946.2 мянган төгрөгөөр урсгал зардлыг бууруулж, 3,536,745.9 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг бараа үйлчилгээний зардлыг 599,848.5 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 88,755.7 мянган төгрөг, нийт 688,604.2 мянган төгрөгөөр урсгал зардлыг бууруулж 2,848,141.7 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,748,141.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,531,311.8 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 211,228.5 мянган төгрөг, нийт 2,742,540.3 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, бараа, ажил, үйлчилгээний зардалд 2,545,109.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 53,510.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 143,921.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,598,619.0 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 233,153.8 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг 5,755.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын дэмжлэгийн зардлыг 10,613.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	2,848,141.7	2,598,619.0	249,522.7	91.2%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,532,253.8	2,299,100.0	233,153.8	90.8%
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	79,801.7	74,046.1	5,755.6	92.8%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	12,625.0	12,625.0	-	100.0%
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	159,338.0	159,337.9	0.1	100.0%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын дэмжлэг	64,123.2	53,510.0	10,613.2	83.4%
81551	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	-	-	-	-

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг 51 орон тоотой байхаар баталсан. Батлагдсан тогтоолын хүрээнд тус газар нь дэд дарга, Мэдээлэл технологийн албаны дарга, ажилтан, тооцооны нягтлан бодогч гэсэн 4 орон тоог хасаж, холбогдох албан тушаалтнуудыг ажлаас чөлөөлсөн байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.3 дахь заалт; Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 8.4 дэх хэсэг, ТӨБЗГ-ын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 5.3.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2025 оны А/49 дүгээр тушаалаар хоолны хөнгөлөлтийг 32,000 төгрөг, унааны хөнгөлөлтийг 3,000 төгрөг байхаар баталсан байна. Тайлант онд гүйцэтгэлээр хоол, унааны хөнгөлөлтөд 301,231.4 мянган төгрөгийг зарцуулсан.

ТӨБЗГ-аас тайлант онд гадаад томилолтын зардлыг 100,337.6 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч төсвийн тодотголоор хасагдсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаар болон монгол бичгийн сургалтыг албан хаагчдын дунд зохион байгуулж тайлант онд 2,000.0 мянган төгрөгийг сургалтын зардалд зарцуулсан байна.

Тайлант онд Мэдээлэл сурталчилгааны арга хэмжээний зардлаас (80205) 1 гүйцэтгэгчтэй хэт богино долгионы фм радио болон пэйж хуудсуудаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ТӨБЗГ-ын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээ, мэдээллийг хүргэх, аудио нэвтрүүлэг, нийтлэл ярилцлага зэргийг байршуулах, түгээх ажлыг гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, гүйцэтгэлээр 4,000.0 мянган төгрөг олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 272,000.0 мянган төгрөгийн 3 ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж баталсан ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 245,000.0 мянган төгрөгийн 2 үйлчилгээ болгон нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Гүйцэтгэлээр шууд худалдан авалтаар 19,800.0 мянган төгрөгийн 1 гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн газрын үйл ажиллагааг сайжруулах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах, дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Батцэцэг, аудитор Ч.Мөнхбулган нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн өмчийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А-1/104 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардалаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 47,290,586.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 472,905.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Энэ нь материаллаг байдлын суурь үзүүлэлт буюу 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 42,707,874.8 мянган төгрөгөөр буурсан тул гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,582,712.0 мянган төгрөгийн 1.0 хувиар тооцож 45,827.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, албан томилолтоор онгоцоор явахад энгийн ангиллаар зорчих, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэхгүй байх, ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалтыг гүйцэтгэх зэргээр хуульд заасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн байршуулбал зохих 163 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь иж бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Төрийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах шийдвэрийн биелэлтийг тус шийдвэрт заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тайлагнадаг боловч тус шийдвэрийн биелэлт оновчтой үнэн зөв хэрэгжсэн эсэхэд тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоолын 8.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь шийдвэрийн биелэлтийг уг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тайлагнана” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах шийдвэрийн биелэлтэд хяналт хэрэгжүүлэх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлсэн.

Аудитын 2,360,090.4 мянган төгрөгийн илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Үүнээс завсрын аудитаар 1,924,727.3 мянган төгрөгийн 4 алдааг залруулсан.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 20,740.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,401,106.5 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 8 албан шаардлага, 6,633,717.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг нотлох баримтад үндэслэн хянаж үнэлэхэд 76.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	20,740.9	1	3,129.3	15.1
Албан шаардлага	8	3,401,106.5	7	3,401,106.5	87.5
Зөвлөмж	3	6,633,717.8	2	1,694,484.9	66.7
Нийт дүн	12	10,055,565.2	10	5,098,720.7	76.3

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Үндэсний аудитын газрын 02/A0171123 дугаартай “Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг болох 20,740.9 мянган төгрөгийг төвлөрүүлэх” төлбөрийн акт тогтоосныг 17,611.6 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн;
- Үндэсний аудитын газрын 02/A0171123 дугаартай “Монголросцветмет” ТӨҮГ-аас Ирээдүй өв сан болон Улсын төсөвт төвлөрүүлэх 24,883,320.0 мянган төгрөгийн ногдол ашгийг төлүүлэх” төлбөрийн акт тогтоосныг 23,383,320.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, “Цемент шохой” ТӨХК-аас улсын төсөвт төвлөрүүлэх 5,815,347.9 мянган төгрөгийн ногдол ашгийг төлүүлэх” төлбөрийн акт тогтоосныг төвлөрүүлээгүй”, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн дутуу төвлөрүүлсэн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;
- Улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг үндэслэлтэй төлөвлөн тогтоох зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Монгол улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг болон төрийн өмчтэй байгууллагын байр талбайн түрээсийн орлогын 40 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 101,600,000.0 мянган төгрөг байхаар тогтоосон. 2025 оны төсвийн жилээс эхлэн дээрх орлогуудыг сангийн яамны төв төрийн сангийн дансанд тайлагнадаг болсон тул дараагийн аудитаар орлогын гүйцэтгэлийг нягтлах;
- Төрийн аудитын байгууллагаас өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Монголросцветмет” ТӨҮГ-аас /хуучин нэршлээр/ Ирээдүй өв сан болон Улсын төсөвт төвлөрүүлэх 24,883,320.0 мянган төгрөгийн ногдол ашгийг төлүүлэх” төлбөрийн акт тогтоосныг 23,383,320.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, “Цемент шохой” ТӨХК-аас улсын төсөвт төвлөрүүлэх 5,815,347.9 мянган төгрөгийн ногдол ашгийг төлүүлэх” төлбөрийн акт тогтоосныг төвлөрүүлээгүй”, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК-аас улсын төсөвт төвлөрүүлэх 17,611.6 мянган төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй, улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг үндэслэлтэй төлөвлөн тогтоох зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зэрэг төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг дахин нягтлах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,898,846.5 мянган төгрөгийн 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 972.0 мянган төгрөгөөр Мөнгөн гүйлгээний тайлангаас зөрүүтэй тайлагнасан нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Тохиолдсон байх, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Санхүүгийн байдлын тайланд 2025 оны 12-р сард ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн ээлжийн амралтын олговор 3,179.8 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Тайлант онд аж ахуйн материал дансанд 2,631.7 мянган төгрөгийн барааг хүлээн аваагүй боловч урьдчилж төлсөн зардлаар тайлагнаагүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч, тайлагнасан нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 2,748,141.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг төвлөрүүлэх шилжүүлгийн 143,921.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь "УСНББОУС 1" Санхүүгийн тайлангийн толилуулга, Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүйг тус тус залруулсан.

Аудитаар нийт 137,911.6 мянган төгрөгийн 7 зөрчил² илэрснээс, 112,504.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 25,407.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 137,911.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 92,084.5 мянган төгрөгөөр давсан тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: "Дулааны IV цахилгаан станц" ТӨХК-ийн 2025 оны төсвийн жилд улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын 40 хувь буюу 101,604.5 мянган төгрөгийг ТӨБЗГ өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т *"төсвийн орлого"* гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т *"үнэн зөв байх"*, 13 дугаар зүйлийн 13.1-д *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн хүрээнд байгууллагын ахмадын сангийн данснаас албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 10,900.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", МУЗГ-ын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-д "Ахмадын сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна", 3.4-т "Ахмадын сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын сангаас албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

3. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн 2,081,726.3 мянган төгрөгийн 6 давхар 5235 м.кв төрийн өөрийн өмчид бүртгэлтэй барилгыг "Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим" ТББ-д үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа зөрчилд өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 6-д "Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар ашиглалтын зардлаар байрлаж болно. Энэ тохиолдолд түрээсийн гэрээ байгуулахгүй, ашиглалтын гэрээ байгуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өөрийн өмчид бүртгэлтэй барилгыг үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, ашиглалтын төлбөрийг харилцан тохиролцож, ашиглалтын төлбөр авах албан шаардлага хүргүүлэх.

4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын илтгэх хуудаст хөрөнгийн бүрэн бүтэн байдал болон эвдрэл гэмтэлтэй хөрөнгийн талаар мэдээлэл тусгаагүй, санхүүгийн программд үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн загвар, нэр, төрөл, байршил, хариуцах эзэн болон хөрөнгөтэй холбогдох мэдээллүүдийг ерөнхий нэршлээр дутуу кодлон бүртгэсэн /ойлгомжтой, давхардахгүй бүртгэх/, хөрөнгө тус бүрд тухайн хөрөнгийн QR кодыг бүртгэн тэмдэглээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д

“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “*өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн бүртгэл, ашиглалтын мэдээллийг бүрэн бэлтгээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Аудитын түүвэрчилсэн тооллогоор бараа материалын дансанд бүртгэлтэй нийт 2,657.0 мянган төгрөгийн дараах хөрөнгүүд биетээр оршин байхгүй байна. Үүнд:

1. Бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй 2,342.0 мянган төгрөгийн өртөгтэй 3 ширхэг ASUS брэндийн Зөөврийн компьютер;
2. Бичиг хэргийн материалын дансанд 18 ширхэг 315.0 мянган төгрөгийн бичгийн цаас;

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д “*өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын дансны бүртгэлийг үнэн зөв хөтлөх, анхан шатны баримтын хүрээнд зарлага гаргах.

2. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийт 22,750.1 мянган төгрөгийн түлш, шатах тослох материалыг оны эцэст худалдан авч, Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, МУЕС-ын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын 1.4-т “*тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах*”, 1.4.1-д “*хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 972.0 мянган төгрөгөөр Мөнгөн гүйлгээний тайлангаас зөрүүтэй тайлагнасан;	1	972.0			1	972.0	1	972.0				
Санхүүгийн байдлын тайланд 2025 оны 12-р сард ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагчийн ээлжийн амралтын олговор 3,179.8 мянган төгрөгийг өглөгөөр бүртгээгүй;	1	3,179.8			1	3,179.8	1	3,179.8				
Тайлант онд аж ахуйн материал дансанд 2,631.7 мянган төгрөгийн барааг хүлээн аваагүй боловч урьдчилж төлсөн зардлаар тайлагнаагүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч, тайлагнасан;	1	2,631.7			1	2,631.7	1	2,631.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 2,748,141.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;	1	2,748,141.7			1	2,748,141.7	1	2,748,141.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг төвлөрүүлэх шилжүүлгийн 143,921.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;	1	143,921.3			1	143,921.3	1	143,921.3				
Дүн	5	2,898,846.5			5	2,898,846.5	5	2,898,846.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн 2,081,726.3 мянган төгрөгийн 6 давхар 5235 м.кв төрийн өөрийн өмчид бүртгэлтэй барилгыг “Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим” ТББ-д үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа зөрчилд өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.	1	-			1	-						
“Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны төсвийн жилд улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын 40 хувь буюу 101,604.5 мянган төгрөгийг ТӨБЗГ өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан байна.	1	101,604.5			1	101,604.5						
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн хүрээнд байгууллагын ахмадын сангийн данснаас албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 10,900.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	10,900.0			1	10,900.0						
Аудитын түүвэрчилсэн тооллогоор бараа материалын дансанд бүртгэлтэй нийт 2,657.0 мянган төгрөгийн дараах хөрөнгүүд биетээр оршин байхгүй байна. Үүнд: 1. Бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй 2,342.0 мянган төгрөгийн	1	2,657.0					1	2,657.0				

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>өртөгтэй 3 ширхэг ASUS брэндийн Зөөврийн компьютер; 2. Бичиг хэргийн материалын дансанд 18 ширхэг 315.0 мянган төгрөгийн бичгийн цаас;.</p>												
<p>Нийт 22,750.1 мянган төгрөгийн түлш, шатах тослох материалыг оны эцэст худалдан авч, Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.</p>	1	22,750.1					1	22,750.1				
<p>Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын илтгэх хуудаст хөрөнгийн бүрэн бүтэн байдал болон эвдрэл гэмтэлтэй хөрөнгийн талаар мэдээлэл тусгаагүй, санхүүгийн программд үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн загвар, нэр, төрөл, байршил, хариуцах эзэн болон хөрөнгөтэй холбогдох мэдээллүүдийг ерөнхий нэршлээр дутуу кодлон бүртгэсэн /ойлгомжтой, давхардахгүй бүртгэх/, хөрөнгө тус бүрд тухайн хөрөнгийн QR кодыг бүртгэн тэмдэглээгүй байна.</p>	1	-			1		-					
<p>Төрийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах шийдвэрийн биелэлтийг тус шийдвэрт заасан хугацаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тайлагнадаг боловч тус шийдвэрийн биелэлт оновчтой үнэн зөв хэрэгжсэн эсэхэд тавих хяналт хангалтгүй байна.</p>	1	-					1	-				
Дүн	7	137,911.6			4	112,504.5	3	25,407.1				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/А0175042

Улаанбаатар хот

САГ-2026/216/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн 2,081,726,270.00 /Хоёр тэрбум наян нэгэн сая долоон зуун хорин зургаан мянга хоёр зуун дал/ төгрөгийн 6 давхар 5236 м.кв төрийн өөрийн өмчид бүртгэлтэй барилгыг "Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим" ТББ-д үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа зөрчилд өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Засгийн газраас тусгайлан журамласнаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдэлнэ", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 6-д "Төрийн өмчийн байранд төсөвт байгууллага, албан газар ашиглалтын зардлаар байрлаж болно. Энэ тохиолдолд түрээсийн гэрээ байгуулахгүй, ашиглалтын гэрээ байгуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3-т "Өмч хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өөрийн өмчид бүртгэлтэй барилгыг үнэ төлбөргүйгээр ашиглуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, ашиглалтын төлбөрийг харилцан тохиролцож, ашиглалтын төлбөр авах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга (Б.Цэнгэл), Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-6.Docx

1526180153



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 80/А0178042

Улаанбаатар хот

САГ-2026/016/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн 2025 оны төсвийн жилд улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогын 40 хувь буюу 101,604,529.93 төгрөг /Нэг зуун нэг сая зургаан зуун дөрвөн мянга таван зуун хорин есөн төгрөг ерэн гурван мөнгө/-ийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т “Төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5-д “Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлогыг өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга (Б.Цэнгэл), Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 81/АД175042

Улаанбаатар хот

САГ-2026/216/НА-СТА-ТШЗ.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хөтөлбөрийн хүрээнд байгууллагын ахмадын сангийн данснаас албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 10,900,000.00 /Арван сая есөн зуун мянга/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-д "Ахмадын сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна", 3.4-т "Ахмадын сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ахмадын сангаас албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга (Б.Цэнгэл), Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН

9006109
ATA16087
9025081411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 82/АД175042

Улаанбаатар хот

САГ-2026/216/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын илтгэх хуудаст хөрөнгийн бүрэн бүтэн байдал болон эвдрэл гэмтэлтэй хөрөнгийн талаар мэдээлэл тусгаагүй, санхүүгийн программд үндсэн хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн загвар, нэр, төрөл, байршил, хариуцах эзэн болон хөрөнгөтэй холбогдох мэдээллүүдийг ерөнхий нэршлээр дутуу кодлон бүртгэсэн /ойлгомжтой, давхардахгүй бүртгэх/, хөрөнгө тус бүрд тухайн хөрөнгийн QR кодыг бүртгэн тэмдэглээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийн бүртгэл, ашиглалтын мэдээллийг бүрэн бэлтгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга (Б.Цэнгэл), Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Ч.МӨНХБУЛГАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 8-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-6.Docx

1526180159